



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	9
3.1	Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	11
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 846
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ





Аудитын тайлан

2.1. Оршил

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Х.Энхжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ажил гүйцэтгэх гэрээнд заасан заалтын дагуу санхүүжилтийг олгож байх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, гэрээт аудитор П.Жаргалмаа нар гүйцэтгэв.

Авлигатай тэмцэх газар 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 03/2810 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар, аргачлалын дагуу горим сорил гүйцэтгэлээ.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Авлигатай тэмцэх газрын дарга Монгол Улсын Авлигын эсрэг хуулиар тогтоосон дор дурдсан чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх зэрэг болно.

Авлигатай тэмцэх газрын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандартын дагуу шинэчлэгдсэн байна.



Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

Харин үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвөөс санхүүждэг байгууллага учраас төсвийн зарцуулалт гол анхаарах асуудал гэж үзэн зардлыг суурь үзүүлэлтээр сонголоо.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг 2018 оны батлагдсан төсвийн 2.0 хувь буюу 269.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй, эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн 16.9 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 1. Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт /сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаа-гүй алдаа, зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагч	1	16.9	-	-	-	-	1	16.9		
2	Төсвийн ерөнхийлөн захирагч	-	-			-	-	-	-	-	-
	Дүн	1	16.9			-	-	1	16.9		

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх 1 асуудлыг Менежментийн захидалд тусгалаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2017 онд Гадаад харилцааны яамны АСЕМ-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хурлын танхимын 14 нэр төрлийн 298 ширхэг тоног төхөөрөмжийн үнэ нь тодорхойгүй хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргаснаас данс бүртгэлд тусгаагүй байна. Дараагийн аудитаар дээрх хөрөнгүүдийн бүртгэлд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Авлигатай тэмцэх газар 2 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 14,845.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 14,832.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Нийт олгогдсон санхүүжилтээс 14,444.4 сая төгрөг зарцуулж, дутуу зарцуулсан 387.9 сая төгрөгийг Төв төрийн санд төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 195.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна. Нэмэлт санхүүжилтээр НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслөөс 123.1 сая төгрөг, Нийслэлийн



ргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 100.0 сая төгрөгийн санхүүжилт олгосныг бүрэн зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Авлигатай тэмцэх газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус газар 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн тайлан, мэдээг бүрэн байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийг гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2018 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд 2 гэрээт ажлын хувьд гүйцэтгэлийг бүрэн хүлээж аваагүй байхад 16.9 сая төгрөгийн үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Урьдчилж төлбөрийг шилжүүлснээр ажил хугацаандаа дуусахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид ажил гүйцэтгэх гэрээнд заасан заалтын дагуу санхүүжилтийг олгож байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр гарын үсэг зуруулж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,499,899.7	7,592,945.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,136,194.2	2,221,572.2
АВЛАГА	7.7	2,900.0
УРЬДЧИЛГАА	567,489.8	2,360,439.5
БАРАА МАТЕРИАЛ	2,796,208.0	3,008,033.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,013,083.4	13,151,399.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,013,083.4	13,151,399.7
Биет хөрөнгө	7,836,231.2	10,924,239.0
Биет бус хөрөнгө	176,852.2	2,227,160.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,512,983.1	20,744,344.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,135,192.2	2,666,348.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,135,192.2	2,264,124.4
Богино хугацаат зээлийн өглөг	-	47,452.2
Өглөг	-	948.0
Урьдчилж орсон орлого	2,135,192.2	2,215,724.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	402,224.3
Урт хугацаат зээл	-	402,224.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,377,790.9	18,077,996.2
Засгийн газрын хувь оролцоо	11,377,790.9	18,077,996.2
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,489,727.6	3,569,468.6
Хуримтлагдсан үр дүн	9,888,063.2	13,143,783.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	1,364,743.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,512,983.1	20,744,344.8

2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,515,838.7	15,390,250.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,802.00	309,602.0
Нийтлэг татварын бус орлого	19,600.8	309,602.0
Тусламжийн орлого	101,201.2	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,395,036.7	15,080,648.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,338,843.8	12,025,872.2
УРСГАЛ ЗАРДАЛ	9,338,843.8	12,025,872.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,080,409.0	11,468,739.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,898,825.1	4,377,391.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,753.5	277,511.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,286.7	87,223.4
Хангамж, бараа материалын зардал	196,443.5	251,390.8
Нормативт зардал	4,086.5	2,455.5
Эд хогшил, урсгал засварын зардал	48,584.6	41,651.0
Томилолт, зочны зардал	82,728.3	129,566.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,092,204.8	4,000,425.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,399,495.8	2,301,124.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,434.9	557,133.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,176,994.9	3,364,378.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	220,067.5	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,375.6	111,773.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,395,686.8	3,252,605.1

3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,604,438.5	15,210,678.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,401.8	130,030.0
Нийтлэг татварын бус орлого	87,112.5	130,030.0
Тусламжийн орлого	122,289.3	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,395,036.7	15,080,648.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,699,132.3	12,335,507.9
УРСГАЛ ЗАРДАЛ	8,699,132.3	12,335,507.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,241,096.8	11,734,724.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,897,362.3	4,375,077.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,753.5	277,511.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,286.7	89,342.9
Хангамж, бараа материалын зардал	194,978.9	228,334.1
Нормативт зардал	4,950.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	63,683.1	47,694.4
Томилолт, зочны зардал	85,594.8	152,434.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,520,207.3	6,133,998.4
Бараа үйлчилгээний бусад зардал	116,280.0	430,332.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	458,035.5	600,783.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,905,306.2	2,875,170.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,001,951.1	2,789,793.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,001,951.1	2,789,793.0
Дотоод эх үүсвэрээр	2,001,951.1	2,789,793.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,001,951.1	-2,789,793.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-797.6	0.0
Бусад эх үүсвэр	566.5	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,364.0	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-97,442.4	85,377.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,233,636.7	2,136,194.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,136,194.2	2,221,572.2



4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1
Тайлант үеийн үр дүн	1,395,686.8	0.0	1,395,686.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,377,790.9	0.0	11,377,790.9
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,377,790.9	0.0	11,377,790.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,115.4	0.0	3,115.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,380,906.3	0.0	11,380,906.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,364,743.7	0.0	1,364,743.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,079,741.0	0.0	2,079,741.0
Тайлант үеийн үр дүн	3,252,605.1	0.0	3,252,605.1
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,077,996.2	0.0	18,077,996.2

.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,136,194.2		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,845,462.0	14,444,351.7	401,110.3	97.3
УРСГАЛ ЗАРДАЛ	14,649,862.0	14,248,766.5	401,095.5	97.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,466,306.4	14,079,617.6	386,688.8	97.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,375,478.3	4,375,077.2	401.1	100.0
Үндсэн цалин	2,675,354.1	2,649,489.7	25,864.4	99.0
Нэмэгдэл	1,544,843.7	1,594,940.1	-50,096.4	103.2
Унаа хоолны хөнгөлөлт	155,280.5	130,647.3	24,633.2	84.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	351,874.2	277,511.1	74,363.1	78.9
Тэтгэврийн даатгал	190,799.4	152,790.6	38,008.8	80.1
Тэтгэмжийн даатгал	22,459.8	17,248.8	5,211.0	76.8
ҮОМШӨ-ний даатгал	17,967.8	17,013.8	954.0	94.7
Ажилгүйдлийн даатгал	4,491.9	3,766.7	725.2	83.9
Эрүүл мэндийн даатгал	116,155.3	86,691.1	29,464.2	74.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,017.1	89,342.9	18,674.2	82.7
Гэрэл, цахилгаан	56,263.8	53,460.0	2,803.8	95.0
Түлш, халаалт	46,305.3	30,669.5	15,635.8	66.2
Цэвэр, бохир ус	5,448.0	5,213.4	234.6	95.7
Хангамж, бараа материалын зардал	234,905.8	234,901.8	4.0	100.0
Бичиг хэрэг	60,294.0	49,915.8	10,378.3	82.8
Тээвэр, шатахуун	75,533.3	73,386.0	2,147.3	97.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,601.7	66,272.7	-3,671.0	105.9
Ном, хэвлэл	4,000.0	3,143.0	857.0	78.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,380.0	1,656.0	724.0	69.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,096.8	40,528.4	-10,431.6	134.7
Эд хогшил, урсгал засварын зардал	69,811.9	69,811.0	0.9	100.0
Багаж, техник, хэрэгсэл	22,512.6	22,512.6	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	806.4	761.6	44.8	94.4
Урсгал засвар	46,492.9	46,536.8	-43.9	100.1



Томилолт, зочны зардал	186,316.6	152,434.1	33,882.5	81.8
Гадаад албан томилолт	40,000.0	39,624.7	375.3	99.1
Дотоод албан томилолт	137,316.6	103,809.5	33,507.1	75.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	9,000.0	8,999.9	0.1	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,928,114.7	8,671,000.6	257,114.1	97.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,747,465.5	8,490,662.2	256,803.3	97.1
Даатгалын үйлчилгээ	20,133.6	20,133.6	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,475.0	2,475.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	528.0	528.0	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,800.0	150,799.2	0.8	100.0
Газрын төлбөр	6,712.6	6,402.6	310.0	95.4
Бараа үйлчилгээний бусад зардал	211,787.8	209,539.0	2,248.8	98.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,118.6	2,118.6	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	209,669.2	207,420.4	2,248.8	98.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	183,555.6	169,148.8	14,406.7	92.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	45,155.6	45,144.4	11.2	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	45,155.6	45,144.4	11.2	100.0
Бусад урсгал шилжүүлэг	138,400.0	124,004.4	14,395.5	89.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,400.0	114,729.0	13,671.0	89.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000.0	9,275.5	724.5	92.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	195,600.0	195,585.3	14.7	100.0
Тоног төхөөрөмж	195,600.0	195,585.3	14.7	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,845,462.0	14,444,351.7	401,110.3	97.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,845,462.0	14,444,351.7	401,110.3	97.3
Улсын төсвөөс санхүүжих	14,845,462.0	14,444,351.7	401,110.3	97.3
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	2,221,572.2	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	85,378.0	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	172	167	5	-
Удирдах ажилтан	13	13	-	-
Гүйцэтгэх ажилтан	146	142	4	-
Үйлчлэх ажилтан	13	12	1	-
Гэрээт ажилтан				



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Авлигатай тэмцэх газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2019.04.24			САГ-2019/23/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Авлигатай тэмцэх газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд 2 гэрээт ажлын хувьд гүйцэтгэлийг бүрэн хүлээж аваагүй байхад үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн.	16.9	Зөвлөмж	Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Ерөнхий нягтлан бодогч	З.Баасанням Х.Саранчимэг
	Дүн	16.9			



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.